



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/5

Улаанбаатар хот

Тогтоолын хэрэгжилтийн талаар
авах арга хэмжээний тухай

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.2, Жендэрийн үндэсний хорооны дүрмийн 2.9, 4.1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлгийн дүгнэлттэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.6 дахь заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай эсэх талаар асуудал боловсруулан, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хорооны гишүүн, Хууль зүй дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Б.Баасандорж/, Хүний эрхийн үндэсний комиссын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ж.Хунан/, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын удирдлага, зохицуулалтын газрын дарга /Ш.Мөнхцэрэн/ нарт үүрэг болгосугай.

2. Тогтоолыг хэрэгжүүлэхэд хорооны гишүүдийг судалгаа, мэдээлэл, баримтаар ханган, дэмжлэг үзүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хорооны нарийн бичгийн дарга /Т.Энхбаяр/-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД,
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
ДАРГА



Л.ОЮУН-ЭРДЭНЭ